



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 22 өдөр

Дугаар A/1050

Улаанбаатар хот

### Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар, “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар, “Хуулийн этгээдийн хураалгасан тамга, тэмдгийн жагсаалт”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Улсын бүртгэлийн гэрчилгээ, баримт бичгээ хүлээн аваагүй хуулийн этгээдийн жагсаалт”-ыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын 1 дэх заалтад заасан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар /Ж.Аюуш/, Улсын бүртгэлийн нэгдсэн архив /С.Оюунгэрэл/, аймаг, нийслэл дэх Улсын бүртгэлийн газар, хэлтсийн дарга наарт, энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 335 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2019 оны дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл 18265215

1.1. Улсын бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээдийн, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын, олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллагын, эсхүл түүний төлөөлөгчийн газрын хувийн хэрэг /цаашид “хувийн хэрэг” гэх/-ийг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлэн хөтлөх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архив /цаашид “архивт” гэх/-т шилжүүлэхэд энэ журмыг баримтална.

1.2. Хувийн хэрэг хөтлөхөд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг дагаж мөрднө.

1.3. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4.8 дахь заалтад зааснаар улсын бүртгэгч хувийн хэргийг хөтөлнө.

1.4. Хувийн хэрэг дахин давтагдахгүй 10 оронтой тооноос бүрдсэн дугаартай байх бөгөөд эхний 2 оронтой тоо уг дугаарыг олгосон улсын бүртгэлийн байгууллагын бүртгэх код, дараагийн 2 оронтой тоо хуулийн этгээдийн хэлбэрийн индекс, сүүлийн 6 оронтой тоо улсын бүртгэлийн мэдээллийн сангаас олгосон дугаар байна.

### Хоёр. Хувийн хэрэг дэх баримт бичгийн төрөл

2.1. Хувийн хэрэг дэх баримт бичиг дараах төрөлтэй байна:

2.1.1. шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн баримт бичиг;

2.1.2. өөрчлөн байгуулах замаар байгуулагдсан хуулийн этгээдийн баримт бичиг;

2.1.3. хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн баримт бичиг;

2.1.4. хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг, олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллагыг, эсхүл түүний төлөөлөгчийн газрыг, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэсэн баримт бичиг;

2.1.5. хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын, олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллагын, эсхүл түүний төлөөлөгчийн газрын, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн баримт бичиг;

2.1.6. хуулийн этгээдэд улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон баримт бичиг;

2.1.7.хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгосон баримт бичиг;

2.1.8.хуульд заасан бусад баримт бичиг;

2.1.9.татан буулгасан хуулийн этгээдийн баримт бичиг.

### **Гурав.Хувийн хэрэг дэх баримт бичгийн дараалал**

3.1.Хувийн хэрэгт шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн баримт бичиг дараах дараалалтай байна:

3.1.1.улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргасан тухайн хуулийн этгээдийн мэдээлэл;

3.1.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх шийдвэр /УБ-08 маягт/;

3.1.4.өргөдөл хүлээн авсан хуудас /УБ-10 маягт/;

3.1.5.шинээр байгуулах хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-03 маягт/;

3.1.6.эцсийн өмчлөгчийн мэдээлэл /УБ-12 маягт/;

3.1.7.тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-13 маягт/;

3.1.8.төрийн байгууллага тамга хийлгэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас олгосон зөвшөөрөл;

3.1.9.хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт /УБ-09 маягт/;

3.1.10.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

3.1.11.хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бол холбогдох нотлох баримт;

3.1.12.хуулийн этгээд байгуулсан шийдвэр /тогтоол, хурлын тэмдэглэл/;

3.1.13.хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан бол үүсгэн байгуулах гэрээ;

3.1.14.хуульд заасан бол эрх бүхий байгууллагын зөвшөөрөл;

3.1.15.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, удирдах зөвлөл, эрх бүхий этгээд нь гадаадын иргэн бол паспортын хуулбар;

3.1.16.хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;

3.1.17.хуульд заасан бусад нотлох баримт бичиг;

3.1.18.шаардлагатай тохиолдолд итгэмжлэл;

3.1.19.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн тухайд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсэгт заасан баримт бичиг.

3.2.Хувийн хэрэгт өөрчлөн байгуулах замаар байгуулагдсан хуулийн этгээдийн баримт бичиг дараах дараалалтай байна:

- 3.2.1.энэ журмын 3.1.1-3.1.4-т заасан баримт бичиг;
- 3.2.2.өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-04 маяг/;
- 3.2.3.энэ журмын 3.1.6-3.1.10-т заасан баримт бичиг;
- 3.2.4.хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсан шийдвэр /тогтоол, хурлын тэмдэглэл/;
- 3.2.5.өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийн дүрэм, хуульд заасан бол гэрээ;
- 3.2.6.хуулийн этгээдийг нийлүүлэх, нэгтгэх тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасны дагуу өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт;
- 3.2.7.өөрчлөн байгуулагдах үеийн санхүүгийн тайлан;
- 3.2.8.энэ журмын 3.1.14-3.1.18-д заасан баримт бичиг;
- 3.2.9.хуулийн этгээдийн тамга, тэмдэг хураалгах шийдвэр /тогтоол, тушаал/, албан бичиг.
- 3.3.Хувийн хэрэгт хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн баримт бичиг дараах дараалалтай байна:
- 3.3.1.энэ журмын 3.1.1-3.1.4-т заасан баримт бичиг;
- 3.3.2.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-05 маяг/;
- 3.3.3.эцсийн өмчлөгчийн мэдээлэл /УБ-12 маяг/;
- 3.3.4.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хэлс төлсөн баримт;
- 3.3.5.эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол, хурлын тэмдэглэл/, өөрчлөлт оруулсан үүсгэн байгуулах баримт бичиг;
- 3.3.6.энэ журмын 3.1.14-3.1.18-д заасан баримт бичигт өөрчлөлт оруулсан тохиолдолд тухайн өөрчлөлт оруулсан баримт бичиг.
- 3.4.Хувийн хэрэгт хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг, олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллагыг, эсхүл түүний төлөөлөгчийн газрыг, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэсэн баримт бичиг дараах дараалалтай байна:
- 3.4.1.улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 3.4.2.энэ журмын 3.1.2-3.1.5-д заасан баримт бичиг;
- 3.4.3.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-05 маяг/;
- 3.4.4.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг бүртгүүлэх өргөдөл /УБ-11 маяг/;
- 3.4.5.тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-13 маяг/;
- 3.4.6.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хэлс төлсөн баримт;

3.4.7.үүсгэн байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол, хурлын тэмдэглэл/;

3.4.8.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын ажиллах журам;

3.4.9.үүсгэн байгуулагч гадаадын хуулийн этгээдийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар;

3.4.10.энэ журмын 3.1.14-3.1.18-д заасан баримт бичиг.

3.5.Хувийн хэрэгт хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын, олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллагын, эсхүл түүний төлөөлөгчийн газрын, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн баримт бичиг дараах дараалалтай байна:

3.5.1.энэ журмын 3.4.1-3.4.3-т заасан баримт бичиг;

3.5.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

3.5.3.өөрчлөлт оруулах эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол, хурлын тэмдэглэл/;

3.5.4.өөрчлөлт оруулсан баримт бичиг;

3.5.5.энэ журмын 3.1.14-3.1.18-д заасан баримт бичигт өөрчлөлт оруулсан тохиолдолд тухайн өөрчлөлт оруулсан баримт бичиг.

3.6.Хувийн хэрэгт хуулийн этгээдэд улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон баримт бичиг дараах дараалалтай байна:

3.6.1.энэ журмын 3.3.1-3.3.4, 3.1.7-3.1.10-т заасан баримт бичиг;

3.6.2.эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол, хурлын тэмдэглэл/;

3.6.3.эрх бүхий байгууллагын шийдвэр;

3.6.4.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.1, 8.8.3 дахь заалтад заасан үндэслэл байвал улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувиар;

3.6.5.улсын бүртгэлийн гэрчилгээ үрэгдүүлсэн, хуулийн этгээдийн нэр өөрчилсөн бол өдөр тутмын сонинд зарлуулсан зар /сонин эх хувиар/;

3.6.6.хуульд заасан бусад баримт бичиг.

3.7.Хувийн хэрэгт хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгосон баримт бичиг дараах дараалалтай байна:

3.7.1.улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.7.2.тамга, тэмдгийн хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-13 маягт/;

3.7.3.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

3.7.4.төрийн байгууллага тамганы хяналтын дугаар дахин авахад Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас олгосон зөвшөөрөл;

3.7.5.эрх бүхий этгээдийн шийдвэр /тогтоол, тушаал/, хүсэлт;

3.7.6.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, оногдуулсан торгох шийтгэлийн хуудас /төлбөрийн баримт/-ын хуулбар;

3.7.7.тамга, тэмдгийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр;

3.7.8.өдөр тутмын сонинд зарлуулсан зар;

3.7.9.хуульд заасан бусад нотлох баримт бичиг.

3.8.Хувийн хэрэгт бусад баримт бичиг дараах дараалалтай байна:

3.8.1.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой шүүхийн шийдвэр, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, албан бичиг;

3.8.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан, цуцалсан баримт бичиг;

3.8.3.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

3.8.4.хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээдийн албан бичиг, шийдвэр;

3.8.5.улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр /УБ-07 маяг/;

3.8.6.тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдсон албан бичиг, өргөдөл, гомдол;

3.8.7.энэ журмын 3.8.6-д заасан албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн баримт бичгийн хуулбар.

3.9.Хувийн хэрэгт татан буулгасан хуулийн этгээдийн баримт бичиг дараах дараалалтай байна:

3.9.1.хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-06 маяг/;

3.9.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хэвлэсэн тухайн хуулийн этгээдийн мэдээлэл;

3.9.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

3.9.4.татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/;

3.9.5.дуусгалтын тайлан;

3.9.6.татвар төлөгчийн хасалтын карт;

3.9.7.өртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа;

3.9.8.тамга, тэмдэг хураалгасан баримт;

3.9.9.татан буулгасан тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар;

3.9.10.улсын бүртгэлийн гэрчилгээ, хэрэв үрэгдүүлсэн бол өдөр тутмын сонинд зарлуулсан зар /сонин эх хувиар/;

3.9.11.хуульд заасан бусад баримт бичиг.

## **Дөрөв.Хувийн хэрэг хөтлөх, архивт хүлээлгэн өгөх**

4.1.Улсын бүртгэгч энэ журмын 3.1-3.9-д заасан хувийн хэрэг дэх баримт бичгийн хуудас бүрийн баруун дээд өнцөт хар өнгийн балаар буюу дугаарлагчаар, хуудас бүрийг хойноос нь урагшаа давхцуулахгүйгээр тод, гаргацтай дугаарлана.

4.2.Улсын бүртгэгч энэ журмын 3.2-3.9-д заасан холбогдох баримт бичгийн хувийн хэрэгт бүрдүүлэхдээ цахим архивт байгаа баримт бичгийн дугаараас үргэлжлүүлэн дугаарлана.

4.3.Улсын бүртгэгч өөрчлөн байгуулах замаар байгуулагдсан хуулийн этгээдийн хувийн хэргийг дараах байдлаар хөтөлнө:

4.3.1.нийлж байгаа хуулийн этгээд тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хүчингүй” тэмдэг дарж, хувийн хэргийг хааж, шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд хувийн хэрэг нээх;

4.3.2.нэгдэж байгаа хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хүчингүй” тэмдэг дарж, хувийн хэргийг нэгтгэсэн хуулийн этгээдийн хувийн хэрэгт нэгтгэж нэг хувийн хэрэг болгох;

4.3.3.хуваагдаж байгаа хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хүчингүй” тэмдэг дарж, хувийн хэргийг хааж, шинээр байгуулагдсан хуулийн этгээд тус бүрд хувийн хэрэг нээх;

4.3.4.тусгаарлах замаар шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд хувийн хэрэг шинээр нээх;

4.3.5.хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдхөд улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хүчингүй” тэмдэг дарж, хувийн хэргийн дугаарыг өөрчилж, хувийн хэргийг үргэлжлүүлэн хөтлөх.

4.4.Улсын бүртгэгч татан буулгасан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хүчингүй” тэмдэг дарж, хувийн хэргийг хаана.

4.5.Улсын бүртгэгч энэ журмын 3.1, 3.2, 3.4-т заасан хувийн хэргийг “Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар, энэ журмын 3.3, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9-д заасан баримт бичгийг “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар тус тус хөтөлж, ажлын 5 өдрийн дотор архивт хүлээлгэн өгнө.

### **Тав.Бусад**

5.1.Хуулийн этгээдийн хаяг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяллаар өөрчлөгдсөн тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувийн хэргийг улсын бүртгэлийн байгууллага хооронд албан бичгээр ажлын 3 өдрийн дотор шилжүүлнэ.

5.2.“Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 1.4-т зааснаар бүртгэл хийсэн улсын бүртгэлийн байгууллага холбогдох баримт бичгийг “Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журам”-ын 4.4-т заасан хугацаанд тухайн хуулийн этгээдийн эх нотлох баримт бичиг хадгалагдаж байгаа улсын бүртгэлийн байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

---оОо---



Улсын бүртгэлийн өрөнхий газрын даргын  
2019 оны 6 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВИЙН ХЭРГИЙГ АРХИВТ ШИЛЖҮҮЛСЭН ЖАГСААЛТ

Улсын бүртгэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: .....

Он, сар, өдөр: .....

## Хүлээлгэн өгсөн:

Улсын бүртгэгч ..... /...../

## Хүлээн авсан:

Архивч ..... /...../ /...../ /...../  
/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2019 оны 1 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙГ АРХИВТ ШИЛЖҮҮЛСЭН ЖАГСААЛТ

5296722 1118266215

Улсын бүртгэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: .....

Он, сар, өдөр: .....

## Хүлээлгэн өгсөн:

Улсын бүртгэгч ..... /Гарын үсэг/ ..... /Гарын үсгийн тайлал/

## Хүлээн авсан:

Архивч ..... /Гарын үсэг/ ..... /...../ /Гарын үсгийн тайлал/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2019 оны № дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУРААЛГАСАН ТАМГА, ТЭМДГИЙН ЖАГСААЛТ**

Улсын бүртгэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: .....

Он, сар, өдөр: .....

Д/д	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Регистрийн дугаар	Тамга, тэмдгийг хураалгасан үндэслэл	Тамга, тэмдгийн дардас

Хүлсэлгээн огсон:

Улсын бүртгэгч ..... / ..... / .....  
/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Хүлээн авсан:

Архивч ..... / ..... / .....  
/Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын  
2019 оны 12 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ, БАРИМТ БИЧГЭЭ ХУЛЭЭН АВААГУЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

Ажилтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: .....  
Он, сар, өдөр: .....

Д/д	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувийн хэргийн дугаар	Регистрийн дугаар	Баримт бичгийн нэр	Хүчинчийн нийтийн авсан он, сар, өдөр	Хулзэн авсан он, сар, өдөр
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						

Баримт бичиг олголт хариуцсан ажилтан

.....  
/Гарын үсэг/

/ .....  
/Гарын үсэг/  
/Гарын үстийн тайлал/